



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/138

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2018 оны 12 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус төвд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 7,000,000 (Долоон сая) төсөвт өртөгтэй түлш халаалтын материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий шатах тослох материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар, 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай. Үүнд:

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Баярмөнх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын
27-ны өдрийн А/138 дугаар захирамжийн
01 дүгээр хавсралт




АРБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД
ТҮЛШ ХАЛААЛТЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-7,000,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
дарга

Гишүүд: О.Чүлтэмжамц-Мөрөн сумын иргэн
Ч.Батжаргал-"Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн нягтлан бодогч
Ц.Нямдорж-Аймгийн Инженерүүдийн холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга: З.Гал-Эрдэнэ-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын
27-ны өдрийн А/138 дугаар захирамжийн
02 дугаар хавсралт



АРБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД
ШАТАХ, ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-14,000,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
дарга

Гишүүд: О.Чүлтэмжамц-Мөрөн сумын иргэн
Ч.Батжаргал-"Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн нягтлан бодогч
Ц.Нямдорж-Аймгийн Инженерүүдийн холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга: З.Гал-Эрдэнэ-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын
27-ны өдрийн А/138 дугаар захирамжийн
03 дугаар хавсралт



АРБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД
ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-4,000,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: О.Чүлтэмжамц-Мөрөн сумын иргэн
Ч.Батжаргал-"Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн нягтлан бодогч
Ц.Нямдорж-Аймгийн Инженерүүдийн холбооны төлөөлөл

Нарийн бичгийн дарга: З.Гал-Эрдэнэ-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн